

ТАВААРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Алт
Газрын тос



АЛТНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 6-р сарын 13

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

Өнгөрөгч долоо хоногт алтны ханш нээлтийн цэгээсээ 1.07%-иар Өслөө. Харин шинэ долоо хоногийн арилжаа нээгдэхэд алтны ханш 0.53 хувиар унаж 1860 ам.доллар боллоо.

Өнгөрсөн долоо хоногийн баасан гарагт хэрэглээний үнийн индекс 1981 оноос хойшхи хамгийн өндөр буюу 8.6 хувь гарснаар инфляцын хэт халаалтыг намдаахын тулд дараагийн хурлаар ХНС бодлогын хүүг хүлээлтээс өндөр нэгжээр нэмэгдүүлэх магадлал бий болсон тул АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд огцом уналт үзүүлээ.

Харин инфляц өндөр үед хамгийн сайн хөрөнгө оруулалт алт гэж үздэг тул тухайн мэдээлэл зарлагдсаны дараагаар алтны ханш нэг өдрийн дотор 2.7 хувиар өссөн байна.

Гэсэн хэдий ч АНУ-ын 10 жилийн хугацаатай төрийн сангийн үнэт цаасны өгөөж 5-р сарын 9-нөөс хойшхи хамгийн дээд цэгтээ хүрсэн нь алтны эрэлтийг тодорхой түвшин хязгаарлалаа.

Мөн ам.долларын ханш сүүлийн дөрвөн долоо хоногийн хамгийн дээд цэгтээ хүрлээ.

Эдийн засгийн тогтворгүй үед алтыг хамгийн сайн хөрөнгө оруулалт гэж үздэг хэдийч одоогийн нөхцөлд алтыг орлох хөрөнгө оруулалтын хэрэгсэлүүд байгаа нь хөрөнгө оруулагчдыг алтыг сонирхохгүй байх гол шалтгаан болж байна.



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



ГАЗРЫН ТОСНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 6-р сарын 13

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

Бээжинд COVID-19 халдварын тохиолдол нэмэгдсэн нь Хятадын шатахууны эрэлт нэмэгдэх магадлалыг бууруулсан тул газрын тосны ханш даваа гарагт уналттай эхэлж байна.

Брент маркийн нефтийн фьючерс 2.06 ам.доллар буюу 1.7%-иар буурч, баррель нь 119.95 ам.доллар болсон бол АНУ-ын баруун Техасын газрын тосны үнэ 2.13 ам.доллар буюу 1.8%-иар буурч 118.54 ам.доллар болжээ.

Хятадын албаны хүмүүс ням гарагт нийслэлд COVID тархаж байгааг анхааруулж, Лхагва гараг хүртэл Бээжинд олон нийтийг хамруулсан масс шинжилгээ хийхээр төлөвлөж байгаагаа зарлалаа.

Баасан гарагт АНУ-ын инфляцийн мэдээлэл огцом өссөний дараа бодлогын хүүг цаашид өсгөх вий гэсэн болгоомжлол дэлхийн санхүүгийн зах зээлд мөн нөлөөлж байна.

Нефть үйлдвэрлэгчид болон боловсруулах үйлдвэрүүд зуны оргил үеийн эрэлт хэрэгцээг хангахын тулд бүх хүчээ дайчлан ажиллаж байна.

Барууны орнуудын нийлүүлэлтийг нэмэгдүүлэхийн тулд дэлхийн тэргүүлэгч экспортлогч Саудын Араб долдугаар сард Хятадаас түүхий нефтийн зарим хэсгийг Европ руу шилжүүлэхээр төлөвлөж байгаагаа мэдэгдлээ.

Golomt_Capital published on TradingView.com, Jun 13, 2022 10:54 UTC+8

Light Crude Oil Futures, NYMEX: O120.19 H120.26 L118.19 C118.65 -2.02 (-1.67%)
 W1A (H1, close, O, SMA, S) 81.92
 W1A (H14, close, O, SMA, S) 85.48



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.